



УЛААНБААТАР, СОФИ ХОТОД ТУС ТУСЫН  
УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМНЫ АЛБАН БАЙР, ОРОН  
СУУЦНЫ ИЖ БҮРЭН БАРИЛГА БАРИХАД ЗОРИУЛАН,  
ХАРИЛЦАН ГАЗАР ОЛГОХ ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ  
МОНГОЛ АРД УЛС, БҮГД НАЙРАМДАХ БОЛГАР АРД  
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХООРОНДЫН  
Х Э Л Э Л Ц Э Э Р

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Болгар Ард Улсын хооронд улам бүр өргөжин хөгжиж байгаа харилцааг харгалзан үзэж тус тусын нийслэл Улаанбаатар, Софи хотод байгаа өөрсдийн дипломат төлөөлөгчдийн газарт албаны болон орон сууцны иж бүрэн барилгатай боломж явдлыг хөнгөвчлөх, тэдний үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилгоор хоёр Талын Засгийн газар доорх зүйлийг хэлэлцэн тохиролцов.

Нэгдүгээр зүйл

Хэлэлцэн Тохирогч Талууд тус тусын нийслэл Улаанбаатар, Софи хотноо суугаа өөрсдийн дипломат төлөөлөгчдийн газруудын хэрэгцээнд албаны болон орон сууцны иж бүрэн барилга барихад зориулан адил хэмжээний газрыг харилцан үнэ төлбөргүй бөгөөд хязгааргүй хугацаагаар олгоно.

а/ Бүгд Найрамдах Болгар Ард Улсын Засгийн газар нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт Софи хотын "Зүүн Өмнөд" хэсгийн 19-р хороололд 9.300 м<sup>2</sup> газар болон уг газар дээр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Элчин сайдын Яамны хэрэгцээнд зориулан албаны ба орон сууцны иж бүрэн барилга барих эрхийг олгоно.

Энэхүү Хэлэлцээрийн саллигүй хэсэг болох I хавсралтанд уг олгох газрын тодорхой байрлал, хиллэх



байдал нь заагдсан болно.

Болгарын Тал дутуу олгогдсон 3.200 м<sup>2</sup> газрыг харилцан тохиролцсон газарт Монголын Талд нэмэн олгоно.

б/ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар нь Бүгд Найрамдах Болгар Ард Улсын Засгийн газарт Улаанбаатар хотын Сүхбаатарын районд Анагаах Ухааны Институтийн зэрэгцээ 12.500 м<sup>2</sup> газар болон уг газар дээр Бүгд Найрамдах Болгар Ард Улсын Элчин сайдын Яамны хэрэгцээнд зориулан албаны ба орон сууцны их бүрэн барилга барих эрхийг олгоно.

Энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг болсон II хавсралтанд уг олгох газрын тодорхой байрлал, хиллэх байдал нь заагдсан болно.

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч Талууд харилцан бие биедээ олгосон газарт барилга барихаас гадна уг газрыг бүрэн эзэмшин ашиглах эрхийг эдлэнэ.

Гуравдугаар зүйл

I-р зүйлийн "а" хэсэгт болон тайлбарт заагдсан газар дээр Болгарын Талын хөрөнгөөр баригдсан барилгууд нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын емч болно.

I-р зүйлийн "б" хэсэгт заагдсан газар дээр Монголын Талын хөрөнгөөр баригдсан барилгууд нь Бүгд Найрамдах Болгар Ард Улсын емч болно.



Дөрөвдүгээр зүйл

I-р зүйлийн "а", "б" хэсэгт болон тайлбарт дурдсан газар дээр барилга барих ба барилгыг өмчлөх эрхийг олгох, хууль зүйн үүднээс батлах явдлыг гагцхүү энэхүү Хэлэлцээрт тулгуурлан өөр ямар нэгэн баримт бичиг, татвар, хураамжгүйгээр харилцан адил үндсэн дээр гүйцэтгэнэ.

Газрыг ямар нэгэн чирэгдэл, бэрхшээлгүйгээр /гуравдахь этгээдийн оролцоогүй/ олгоно.

Тавдугаар зүйл

Элчин сайдын Яамдын албан байр, дипломат төлөөлөгчдийн газрын ажилтнуудын орон сууц нь Хэлэлцэн Тохирогч Талуудын хот тохижуулалт болон уран барилгын хэм хэмжээний дагуу баригдсан байвал зохино.

Зургадугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч Талууд барилгын ажил эхлэхээс нэг сарын өмнө уул газрыг цэвэрлэж барилгын ажил эхлэхэд саадгүй болгох үүрэг авч байна.

Улаанбаатар, Софи хотуудад олгосон газар дээр баригдах барилгуудыг ашиглахад зайлшгүй шаардагдах ус дамжуулах хоолой, суваг, дулаан түгээгүүр, гудамжны гарц, харилцаа холбооны шугам сүлжээ зэрэг ахуй хангамжийн системээр хангах үүргийг хоёр Тал хүлээж байна.

Долдугаар зүйл

I-р зүйлийн "а", "б" хэсэгт заагдсан газар дээр Улаанбаатар, Софи хотуудад баригдсан барилгыг Хэлэлцэн Тохирогч нөгөө Талын зөвшөөрөлгүй гуравдахь этгээдэд нилжүүлэн өгөх, ашиглуулах буюу худалдаж үл болох тухай Хэлэлцэн Тохирогч Талууд мэдэгдэж байна.



Наймдугаар зүйл

Барилгын зураг төсөл гаргах түүний төлбөртэй холбогдсон асуудлыг зохицуулах тухай тусгай Протоколуудыг нэмж байгуулахаар Хэлэлцэн Тохирогч Талууд тохиролцов.

Есдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Болгар Ард Улсад тус бүр нэг хувийг хадгалуулахаар монгол, болгар, орос хэл дээр адил хүчинтэй хоёр эх хувь үйлдэх, хэрэв эх хувийг тайлбарлахад маргаан гарвал орос эхийг шийдвэрлэгч гэж үзнэ. 1974 оны 2 дугаар сарын "9"-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурав.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД  
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ  
ОЛГОСНООР

БҮГД НАЙРАМДАХ БОЛГАР АРД  
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ  
ОЛГОСНООР